



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 12 сарын 12 өдөр

Дугаар 522

Улаанбаатар хот

Аргачлал шинэчлэн батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.14, 9.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

- “Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтоох аргачлал”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
- Батлагдсан аргачлалын дагуу түлшний үнийг тооцохыг эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлш нийлүүлэх аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд, түлшний үнийн тооцоог хянахыг Үнэ тариф, зах зээлийн газар /Б.Болор-Эрдэнэ/-т үүрэг болгосугай.
- Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Г.Эрхэмбаяр/-нд даалгасугай.
- Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Аргачлал батлах тухай” 2015 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

ЗОХИЦУУЛАГЧ

А.ТЛЕЙХАН


Э.ТҮВШИНЧУЛУУН

Б.БАТТУЛГА

У.МЯГМАРСҮРЭН

Б.АМАРСАНАА

Эрчим хүчний зохицуулах хорооны
2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
522 дугаар тогтоолын хавсралт



ЭРЧИМ ХҮЧ ҮЙЛДВЭРЛЭХЭД АШИГЛАХ ТҮЛШНИЙ ҮНИЙГ ТОГТООХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү аргачлалын зорилго нь эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах зориулалтаар эрчим хүчний эх үүсвэрт нийлүүлэх түлш /нүүрс, занар, мазут, газрын тос, уран ба торийн хүдэр, тэдгээрийн дагавар бүтээгдэхүүн болон баяжмал, байгаль дээр оршиж байгаа биомасс, бусад органик материал, хийн түлш/-ний үнийг тооцож тогтоох, тооцоог хянахад оршино.

Хоёр. Нэр томъёо

Энэхүү аргачлалд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1. **Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ (БО_ш)** – Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшийг олборлох, боловсруулах, импортлох, худалдан авах, тээвэрлэх зэрэг эрчим хүчний эх үүсвэрт нийлүүлэх үйл ажиллагаатай холбоотой нийт зардал, хөрөнгө оруулалтын өгөөжийг тусгасан борлуулалтын орлого;

2.2. **Нийт зардлын дүн (НЗ)** – Борлуулалтын өртөг, борлуулалт маркетингийн зардал, ерөнхий ба удирдлагын зардал болон урт хугацаат зээлийн хүү болон түүнтэй холбоотой үүссэн зардлаас бусад бүх төрлийн зээлийн хүү, түүнтэй холбоотой үүссэн зардлын нийлбэр;

2.3. **Хөрөнгө оруулалтын өгөөж (ХО_ө)** – Хөрөнгө оруулалтаас олох урт хугацаат зээлийн хүүгийн зардал, ажиллагсдын нийгмийн зардлыг тусгасан ашгийн хэмжээ;

2.4. **Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь (ХО_{ө.х})** – Урт хугацаат зээлийн хүү, өөрийн хөрөнгийн өгөөжийн хувийн жигнэсэн дундаж

2.5. **Татаас (TC_ө)** - Засгийн газрын эрх бүхий байгууллагаар баталгаажсан санхүүжилтийн эх үүсвэр;

2.6. **Үйлчилгээний биет хэмжээ (Ү_{б.х})** – Эрчим хүчний эх үүсвэрт нийлүүлэх түлшний тоо хэмжээ;

Гурав. Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг тогтооход баримтлах зарчим

3.1. Түлш нийлүүлэх үйл ажиллагааны зардлыг сүүлийн 3 жилийн бодит өртөг зардлын гүйцэтгэлд үндэслэн тооцно.

3.2. Түлш нийлүүлэх үйл ажиллагааны зардалд ирээдүйд хийгдэх хөрөнгө оруулалт, шинэчлэлийн үр дүнд ирээдүйд бий болох хөрөнгө, эх үүсвэр, үр дүнд ирээдүйд бий болох хөрөнгө, Засгийн газрын буцалтгүй тусlamж, улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон бусад хандив, тусlamжаар авсан

Үндсэн хөрөнгөнд тооцогдох элэгдэл, хорогдлын зардлыг тусгахгүй. Хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн дүнгийн зөрүүнд тооцсон элэгдлийн зардлыг дахин үнэлгээ хийх үндэслэл, хөрөнгийн ашиглалтын байдал, дахин үнэлгээ хийсэн тайлан болон бусад холбогдох мэдээллийг харгалзан үзсэн үндсэн дээр үйл ажиллагааны зардалт тооцох эсэхийг шийдвэрлэнэ.

3.2. Үйл ажиллагааны зардалт энэхүү аргачлалын 2.1-д заасан үйл ажиллагаанд хамааралгүй бүх төрлийн шагнал урамшуулалт тэтгэмж, бусдад өгсөн хандив, бэлэг дурсгал, хүлээн авалт, туслах аж ахуй, амралт, сувилал, гуанз, цайны газрын зардал ба бусад үйлдвэрлэлийн бус үйлчилгээний зардлыг оруулахгүй.

3.3. Засгийн газрын эрх бүхий байгууллагаар санхүүжилтийн эх үүсвэр нь баталгаажсан нөхцөлд татаасыг борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд орлого хэлбэрээр оруулж тооцно.

3.4. Хэрэглэгчийн эрчим хүчиний үнэ тарифт өөрчлөлт орсон нөхцөлд орлогын эх үүсвэртэй уялдуулан эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийн тооцоог хянана.

3.5. Энэхүү аргачлалаар эрчим хүчиний эх үүсвэрийн үндсэн түлшний үнийг тооцох бөгөөд галлагааг дэмжих зориулалтаар ашиглаж буй түлшний үнийг тооцохгүй.

Дөрөв. Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийн тооцоо

4.1. Түлшний үнийг тооцохын тулд борлуулалтын орлогын шаардагдах хэмжээг тодорхойлно. Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ /БОш/ нь үйл ажиллагааны нийт зардал /НЗ/-ын дүн болон хөрөнгө оруулалтын өгөөж /ХОӨ/-ийн нийлбэрээр тодорхойлогдоно.

$$\text{БОш} = \text{НЗ} + \text{ХОӨ}$$

4.2. Нийт зардлын дүн /НЗ/- нь борлуулалтын өртөг /БӨ/, борлуулалт маркетингийн зардал /БМЗ/, ерөнхий ба удирдлагын зардал /ЕУЗ/ болон богино хугацаат зээлийн хүүгийн зардал /З_{хүү}/ын нийлбэрээр тодорхойлогдоно.

$$\text{НЗ} = \text{БӨ} + \text{БМЗ} + \text{ЕУЗ} + \text{З}_{\text{хүү}}$$

4.3. Хөрөнгө оруулалтын өгөөж /ХОӨ/-ийг тодорхойлоходо өгөөж тооцох хөрөнгө оруулалт /ХО_{өт}/ын дүнг хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь /ХО_{өх}/иар үржүүлнэ.

$$\text{ХОӨ} = \text{ХО}_{\text{өт}} * \text{ХО}_{\text{өх}}$$

4.3.1. Өгөөж тооцох хөрөнгө оруулалтын дүн /ХО_{өт}/ нь өгөөж тооцох үндсэн хөрөнгийн дүн /YХ_{өт} / болон өгөөж тооцох эргэлтийн хөрөнгө /ЭХ_{өт} /ийн нийлбэртэй тэнцүү байна.

$$\text{ХО}_{\text{өт}} = \text{YХ}_{\text{өт}} + \text{ЭХ}_{\text{өт}}$$

4.3.2. Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь /ХО_{өх}/ нь хөрөнгө оруулалтын эх үүсвэрүүдийн өгөөжийн хувийн жигнэсэн дунджаар тодорхойлогдоно. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр нь урт хугацаат зээл, эзэмшигчийн хөрөнгөөс бүрдэнэ.

$$X_{Oex} = \frac{(YX_3 * YX_3 xx) + (\Theta * \Theta ex)}{YX_3 + \Theta}$$

4.3.3. Өгөөж тооцох үндсэн хөрөнгийн дүн / YX_{et} / -г үндсэн үйл ажиллагаатай холбогдох үндсэн хөрөнгө / YX / -ийн анхны өргөөс хуримтлагдсан элэгдэл / ΘL / -ийг хасаж тодорхойлно.

$$YX_{et} = YX - \Theta L$$

4.3.4. Өгөөж тооцох эргэлтийн хөрөнгийн дүн / ΘX_{et} / -г үндсэн үйл ажиллагаатай холбогдох эргэлтийн хөрөнгө / ΘX / -өөс богино хугацаат өр төлбөр / ΘT_{bx} / -ийг хасаж тооцно.

$$\Theta X_{et} = \Theta X - \Theta T_{bx}$$

4.4. Түлшний үнийг борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ / BO_w / -нээс Засгийн газрын эрх бүхий байгууллагаар баталгаажсан татаас / TC_{3g} / -ыг хасаж үйлчилгээний биет хэмжээ / Y_{bx} / -нд харьцуулж дараах байдлаар тодорхойлно.

$$Y_T = \frac{BO_w - TC_{3g}}{Y_{bx}} \quad \{t\text{өг/tн, t\text{өг/m}^3 г.м}\}$$

Тав. Түлшний үнийг индексжүүлж тогтоох

5.1. Түлш нийлүүлэх үйл ажиллагааны зардлын үндсэн хүчин зүйлсийн бодит өөрчлөлтөөс хамааруулан дараах зардлуудыг индексжүүлнэ.

5.1.1. Гадаад валютын ханшны өөрчлөлт ба гадаад орны үйлдвэрлэгчийн үнийн индексийн нөлөөллийг түлш, шатахуун, сэлбэг хэрэгсэл гэх мэт хамаарал бүхий зардлыг тооцоход;

5.1.2. Монгол улсын хэрэглээний үнийн индексийн нөлөөллийг үндсэн ба нэмэгдэл цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл болон ажиллагсдын нийгмийн асуудалтай холбоотой зардлыг тооцоход;

5.1.3. Үйлдвэрлэгчийн үнийн индексийн нөлөөллийг түүхий эд материал, тээвэр, материал, хангамжийн материал, албан томилот, конторын хангамж, харилцаа холбоо, харуул хамгаалалт, хөдөлмөр хамгаалал, даатгал, байгаль орчин хамгаалах, галын аюулаас хамгаалах, гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл, борлуулалт, маркетинг, диспетчер, зохицуулалтын үйлчилгээний хөлс, гадны үйлчилгээний хөлс, түрээс, сургалт, найдваргүй авлага, аваарийн нөөц, үйл ажиллагааны бусад зардлыг тооцоход;

5.1.4. Татвар, хууль, шийдвэрийн өөрчлөлтийн нөлөөллийг усны зардал, эрчим хүч болон ус ашиглалтын зардал, орлогын албан татвараас бусад татвар, шимтгэл, элэгдэл, хөрөнгө оруулалтын өгөөж (урт хугацаа зээлийн хүүгийн зардал, ашиг)-ийн зардлыг тооцоход;

5.1.5. Нийлүүлэх түлшийг худалдан авах, импортлох үйл ажиллагаа явуулдаг тохиолдолд үнийн өөрчлөлт болон холбогдох валютын ханшны өөрчлөлт, худалдан авах биет хэмжээний өөрчлөлтийг борлуулалтын өргөгийг тооцоход.

5.2. Түлшний үнийг дараах байдлаар индексжүүлнэ. Үүнд:

$$Y_T = \frac{BO_w + BO_{w.oeprch} - TC_{3g}}{Y_{bx} + Y_{bx.oeprch}}$$

5.2.1. Индексжуулсэн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ /БО_ш+БО_{ш.өөрч}/-ийг дараах байдлаар тодорхойлно.

$\text{БО}_{\text{ш}} + \text{БО}_{\text{ш.өөрч}} =$	$+ \text{Зардал}_1 \times [\text{ХЖ}_1 \times (\text{YYИ}_{\text{го}} \times \text{ГВХ}) + (1 - \text{ХЖ}_1)]$ $+ \text{Зардал}_2 \times [\text{ХЖ}_2 \times \text{ХҮИ}_{\text{мон}} + (1 - \text{ХЖ}_2)]$ $+ \text{Зардал}_3 \times [\text{ХЖ}_3 \times \text{YYИ}_{\text{мон}} + (1 - \text{ХЖ}_3)]$ $+ \text{Зардал}_4 + \text{Зардал}_{4.\text{өөрч}}$ $+ \text{Зардал}_{5.\text{бө}} + \text{Зардал}_{5.\text{бө.өөрч}}$ $+ \text{ХО-ЫН ӨГӨӨЖ}$
Зардал ₁	<p>Гадаад валютын ханшны өөрчлөлт ба гадаад орны үйлдвэрлэгчийн үнийн индексийн нөлөөллийг тооцох зардал;</p>
ХЖ ₁	<p>Гадаад валютын ханшны өөрчлөлт ба гадаад орны үйлдвэрлэгчийн үнийн индексийн нөлөөллийн зардалд эзлэх хувийн жин;</p>
YYИ _{го}	<ul style="list-style-type: none"> - Гадаад орны үйлдвэрлэгчийн үнийн индекс;
ГВХ	<ul style="list-style-type: none"> - Гадаад валютын ханшны өөрчлөлтийн индекс;
Зардал ₂	<ul style="list-style-type: none"> - Хэрэглээний үнийн индексийн нөлөөллийг тооцох зардал;
ХЖ ₂	<ul style="list-style-type: none"> - Хэрэглээний үнийн индексийн нөлөөллийн зардалд эзлэх хувийн жин;
ХҮИ _{мон}	<ul style="list-style-type: none"> - Монгол улсын хэрэглээний үнийн индекс;
Зардал ₃	<ul style="list-style-type: none"> - Үйлдвэрлэгчийн үнийн индексийн нөлөөллийг тооцох зардал;
ХЖ ₃	<ul style="list-style-type: none"> - Монгол улсын үйлдвэрлэгчийн үнийн индексийн нөлөөллийн зардалд эзлэх хувийн жин;
YYИ _{мон}	<ul style="list-style-type: none"> - Үйлдвэрлэгчийн үнийн индексийн нөлөөллийн регресс;
Зардал ₄	<ul style="list-style-type: none"> - Татвар, хууль, шийдвэрийн өөрчлөлтийн нөлөөллийг тооцох зардал;
Зардал _{4.өөрч}	<ul style="list-style-type: none"> - Татвар, хууль, шийдвэрийн өөрчлөлт нөлөөллийг тооцсон зардлын өөрчлөлт;
Зардал ₅	<ul style="list-style-type: none"> - Түлш худалдан авах, импортлох нөлөөллийг тооцох зардал /борлуулалтын өртөг/;
Зардал _{5.өөрч}	<ul style="list-style-type: none"> - Түлш худалдан авах, импортлох нөлөөллийг тооцсон зардал /борлуулалтын өртөг/-ын өөрчлөлт;

5.3. Гадаад валютын ханшны өөрчлөлт, гадаад орны үйлдвэрлэгчийн үнийн индекс, хэрэглээний үнийн индекс, үйлдвэрлэгчийн үнийн индексийн хүчин зүйлийн нөлөөллийн холбогдох үйл ажиллагааны зардалд эзлэх хувийн жинг дараах байдлаар тогтооно.

5.3.1. Тухайн индексжуулэлт хийх хугацааны оноос өмнөх 10-аас доошгүй жилийн хугацаан дахь зардалд нөлөөлөх хүчин зүйлс болон үйл ажиллагааны зардлын өсөлтийн хоорондын хамаарлыг тогтоож, регрессийн шинжилгээ хийнэ.

5.3.2. Регрессийн шинжилгээгээр индексжуулэлт хийх хугацаан дахь зардалд нөлөөлөх хүчин зүйлс болон холбогдох зардлын өсөлтийг тогтооно.

5.3.3. Регрессийн шинжилгээгээр тооцож гаргасан зардлын өсөлтийн хувийг хүчин зүйлсийн өсөлтийн хувьд харьцуулж, холбогдох үйл ажиллагааны зардалд хүчин зүйлсийн нөлөөллийн эзлэх хувийн жинг тодорхойлно.

Зургаа. Бусад

5.1. Түлшний үнийн тооцоо нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

5.1.1. Энэхүү аргачлалын дагуу хийгдсэн байх,

5.1.2. Аливаа арифметик алдаагүй байх,

5.1.3. Тооцоонд ашигласан мэдээлэл үнэн зөв, бодитой, нотлогдсон байх,

5.1.4. Үнийн тооцоонд аливаа өртөг зардал нь жишиг үзүүлэлт /бенчмаркинг/-д нийцсэн байх.

5.2. Түлшний үнийг тооцох, үнийн тооцоог хянахад дараах үндсэн маягтыг ашиглана. Үүнд :

5.2.1. Эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлш /түлшний төрөл/ үнийн тооцоо /Хүснэгт 1/,

5.2.2. Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ /Хүснэгт 2/,

5.2.3. Техник-эдийн засгийн үзүүлэлт /Хүснэгт № 3/,

5.3. Түлшний үнийн тооцоонд сүүлийн жилүүдийн зардлын бодит гүйцэтгэлтэй холбоотой зардлын төрөл тус бүрээр гарсан тайлан тооцоо, дэлгэрэнгүй задаргаа тооцоолол, зардал болон хөрөнгө оруулалтын өгөөж төрөл тус бүрийн нотлох баримт /холбогдох гэрээ хэлцэл, хууль эрх зүйн актууд, техник эдийн засгийн үндэслэл, эрх бүхий байгууллагын шийдвэр, батлагдсан норм, норматив, хөндлөнгийн эрх бүхий байгууллагын гаргасан дүгнэлт, шаардлага, зөвлөмж болон бусад шаардлагатай баримт бичиг, материал/-ыг хавсаргасан байна.

5.4. Түлш нийлүүлэх үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, дотоод эрсдэлт хүчин зүйлээр үл хамааран, гадаад орчинд зардлын үндсэн хүчин зүйлсийн бодит өөрчлөлт гарсан тохиолдолд түлшний үнийг индексжуулэн тогтоож болно.

..... -ний эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлш /түлшний төрөл/ үнийн тооцоо

№	Үзүүлэлтүүд	мөрийн дугаар	хэмжих нэгж	Дүн
1	Үнэ (3/2)	1	төг/...	
2	Үйлчилгээний биет хэмжээ	2	...	
3	Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ (4+9-18)	3	м.төг	
4	Нийт зардлын дүн (5+6+7+8)	4	м.төг	
	Борлуулалтын өртөг	5	м.төг	
	Борлуулалт маркетингийн зардал	6	м.төг	
	Ерөнхий ба удирдлагын зардал	7	м.төг	
	Богино хугацаат зээлийн хүүгийн зардал	8	м.төг	
5	Хөрөнгө оруулалтын өгөөж (10x11)	9	м.төг	
6	Хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь	10	%	
7	Өгөөж тооцох хөрөнгө оруулалтын дүн (12+15)	11	м.төг	
8	Өгөөж тооцох үндсэн хөрөнгийн дүн (13-14)	12	м.төг	
	Үндсэн хөрөнгө	13	м.төг	
	Хуримтлагдсан элэгдэл	14	м.төг	
9	Өгөөж тооцох эргэлтийн хөрөнгийн дүн (16-17)	15	м.төг	
	Нийт эргэлтийн хөрөнгө	16	м.төг	
	Богино хугацаат өр төлбөр	17	м.төг	
10	Татаасын орлого	18	м.төг	

Бортуулалтын орлогын шаардлагатай мэжүүх хийн

-----НИЙ ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Д/Д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Гүйцэтгэл			Үнийн тооцоо он
		 он он он	
1	Техникийн үзүүлэлт					
1.1	...					
1.2	...					
1.3	...					
1.4	Түлшний биет борлуулалт	биет				
1.5	Эрчим хүчний түлшний борлуулалт	биет				
1.6	бусад түлшний борлуулалт	биет				
2	Эдийн засгийн үзүүлэлт					
2.1	Борлуулалтын орлого	мян.төг				
2.2	Түлшний борлуулалт	мян.төг				
2.3	- Эрчим хүчний түлш	мян.төг				
2.4	- Бусад түлш	мян.төг				
2.5	Бусад орлого	мян.төг				
2.6	Нийт зардал	мян.төг				
2.7	Эрчим хүчний түлш нийлүүлэх үйл ажиллагааны зардал	мян.төг				
2.8	Бусад түлшний үйл ажиллагааны зардал	мян.төг				
2.9	Бусад зардал	мян.төг				
2.10	Нийт ашиг, алдагдал	мян.төг				
2.11	Эрчим хүчний түлшний үйл ажиллагааны ашиг	мян.төг				
2.12	Бусад түлшний үйл ажиллагааны ашиг	мян.төг				
2.13	Түлшний нэгжийн үнэ	төг/биет				
2.14	Түлшний нэгжийн өртөг	төг/биет				
3	Санхүүгийн үзүүлэлт					
3.1	Эргэлтийн хөрөнгө	мян.төг				
3.2	Авлага	мян.төг				
3.3	Бараа материал	мян.төг				
3.4	Үндсэн хөрөнгө	мян.төг				
3.5	Нийт хөрөнгө	мян.төг				
3.6	Богино хугацаат өр төлбөр	мян.төг				
3.7	Урт хугацаат өр төлбөр	мян.төг				
3.8	Эзэмшигчийн өмчийн дүн	мян.төг				
4	Бусад үзүүлэлт					
4.1	Ажиллагсдын тоо	хүн				
4.2	Сарын дундаж цалин	мян.төг/хүн				
4.3	Цалингийн зардал	мян.төг				